

МОНГОЛ-ОРОСЫН ХАРИЛЦААНД НАЙРАМДЛЫН НИЙГЭМЛЭГҮҮДИЙН ГҮЙЦЭТГЭЖ БУЙ ҮҮРЭГ, РОЛЬ

*Ж.Гүррагчаа**

Эрхэм хүндэт УИХ-ын дарга аа!

Хүндэт зочид, төлөөлөгчид өө!

Өнөөдөр Монголын олон нийтийн хувьд түүхэн тэмдэглэлт үйл явдал болж байна. 60 жилийн тэртээ, 5 дугаар сарын энэ өдрүүдэд гадаад орнуудтай найрамдал, соёлоор харилцах Монголын анхны Нийгэмлэг болох “ЗХУ-тай соёлоор харилцах Нийгэмлэг” байгуулагдсан нь тэр үеийн Монголын олон нийтийн хувьд түүхэн тэмдэглэлт үйл явдал болсон төдийгүй Зөвлөлтийн ард түмэнтэй тогтоосон найрамдлыг бэхжүүлэх, бүх талын хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чин хүсэл эрмэлзлэл бүхий Монголын олон нийтийн хөдөлгөөний зохион байгуулалтын оргил нь болсон юм.

Монголын олон нийтийн санаачлагаар Гадаадтай соёлоор харилцах нийгэмлэг байгуулагдсан явдал нь өөрөө, тэр үеийн Монгол орны нийгмийн амьдралд их итгэл найдвар төрүүлэхүйц, цоо шинэ үзэгдэл болсон юм.

МОКС нь байгуулагдсан цагаасаа эхлэн тусгаар тогтносон улс хоорондын найрсаг харилцааг хөгжүүлэх үйлсэд ард нийтийг хүсэл зоригийнх нь дагуу дайчлан ажиллаж эхэлжээ. Тэрээр өсөн өндийх, хөгжин дэвжих 60 жилийн яруу алдарт замыг туулсан юм.

60 жилийн өндөрлөгөөс МОКС-ын туулсан замыг дүгнэн үзэхэд дараах гурван үе шат тодрон харагдаж байна.

Нэгдүгээр үе шат (1947-1955)

1947 оны 5 дугаар сарын 22-нд байгуулагдсан ЗХУ-тай соёлоор харилцах Монголын Нийгэмлэг буюу манай ахмад, дунд үеийнхний хэлж заншсан МОКС-ын гол зорилго нь Зөвлөлтийн ард түмэнтэй тогтоосон найрамдал, бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх явдал байв.

МОКС байгуулагдсан үеэсээ эхлэн Гадаад орнуудтай найрамдал, соёлоор харилцах Бүх Холбоотын Нийгэмлэгтэй (ВОКС) ажил хэргийн нягт харилцааг тогтоож, энэхүү байгууллагын байнгын дэмжлэг туслалцаанд тулгуурлан өөрийн үйл ажиллагаагаа явуулж ирсэн юм.

МОКС-ын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь лекц яриа хийх, зөвлөлтийн соёл, урлаг, утга зохиолын үзэсгэлэн гаргах, кино жүжиг

* Ж.Гүррагчаа - Монголын Эвлэлийн тэргүүн, УИХ-ын гишүүн, сансрын нисгэгч, ЗХУ ба Монголын Улсын баатар

үзүүлэх, найрамдлын үдэшлэг уулзалт зохиох, ЗХУ-ын УААА, соёлын тухай ном товхимол гаргах, урлагийн мастеруудын хамтарсан тогтолтыг зохион байгуулах, зөвлөлтийн ард түмний амьдрал, Монгол-Зөвлөлтийн найрамдлын түүхэн дэх тэмдэглэлт ой, үйл явдлуудыг тэмдэглэх зэрэг байсан бөгөөд соёлын ажил, арга хэмжээгээр дамжуулан Зөвлөлтийн ард түмний олсон ололт амжилт, туршлагыг Монголын олон нийтэд өргөн сурталчилж байв. Ард түмнүүдийн хоорондын найрамдал, нөхөрлөлд чухамхүү соёл, урлаг хамгийн том гүүр болж байдаг. Ийм ч учраас МОКС нь анх байгуулагдахдаа “Соёлоор харилцах нийгэмлэг” гэсэн нэртэйгээр байгуулагдаж байсан учиртай юм.

МОКС-оос манай хоёр орны ард түмнүүдийн найрамдалт харилцааг бэхжүүлэхэд оруулсан нэг том хувь нэмэр бол Октябрийн хувьсгалын 35 жилийн ойд зориулан 1952 оноос эхлэн зохион явуулсан Монгол-Зөвлөлтийн найрамдлын Сарын ажил байв. 60 жилийн хугацаанд Найрамдлын нийгэмлэг Монгол-Зөвлөлтийн болон Монгол-Оросын Найрамдлын 46 сарын ажлыг зохион явуулжээ. ЗХУ, түүний бүрэлдэхүүнд байсан бараг бүх бүгд найрамдах улсуудад Зөвлөлт-Монголын найрамдлын сар, 10 хоногийн ажлуудыг Монгол ардын хувьсгалын ойг угтан ЗМНН-тэй хамтран зохион явуулдаг байв. Найрамдлын сарын ажил нь манай хоёр орныг сурталчлах соёл, сурталчилгааны томоохон цогц арга хэмжээ төдийгүй хоёр орны олон нийтийн хамтран ажиллах ажиллагааны үр өгөөжтэй хэлбэр байсан, одоо ч байгаа гэдгийг энэ ялдамд онцлон тэмдэглэхийг хүсч байна.

Монгол орныг гадаадад таниулах, монголын ард түмнийг дэлхийн соёл иргэншилтэй өргөн танилцуулахад МОКС их чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Үүний нэг тод жишээ нь МОКС-ын байгуулагдсан үеэсээ эхлэн явуулж байсан монголын олон нийтийн дунд орос хэлийг заан сургах, түгээн дэлгэрүүлэх ажил байлаа.

Хоёрдугаар үе шат (1955-1991)

Энэ үе шат нь Монгол-Зөвлөлтийн найрамдал, хамтын ажиллагааны шинэ үе шаттай уялдан бий болсон юм. Энэ нь улс орныг үйлдвэржүүлэх, атар газрыг эзэмших, орчин үеийн хот суурин бий болгох их бүтээн байгуулалтын үе байв. Ийм ч учраас 1955 оны бүгд хурлаараа МОКС-ын нэрийг өөрчилж “Монгол-Зөвлөлтийн найрамдлын Нийгэмлэг” гэж нэрлэхээр шийдвэрлэж, нийгэмлэгийн Дүрэмд өөрчлөлт оруулжээ.

Найрамдлын нийгэмлэгийн түүхэн хөгжлийн II үе шат нь МЗНН-ийн эрчтэй, олон талт үйл ажиллагааны хэмжээ, далайцаар

тодорхойлогдож байгаа юм. Энэ үе шатны бас нэг онцлог нь 1958 онд Монголын энх тайван, найрамдлын байгууллагуудын Холбоо байгуулагдаж, үүний дараа бусад оронтой найрамдах, хамтран ажиллах энх тайван, найрамдлын нийгэмлэг, байгууллагууд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн үе юм. МОКС нь энэ утгаар дараа дараачийн найрамдлын бусад байгууллагуудын дүр төрх болж, үүсч хөгжих үндэс суурийг тавьсан гэж хэлж болно.

Ийм ч учраас жил бүрийн 5 дугаар сарын 22 бол гадаадтай соёлоор харилцах Монголын анхны нийгэмлэг байгуулагдсан өдөр төдийгүй Монгол Улсад найрамдлын байгууллагууд үүсч хөгжсөн өдөр хэмээн үзэх бүрэн үндэстэй түүхэн тэмдэглэлт өдөр гэж бид үздэг учиртай.

Энэ үе шатнаас эхлэн нийгэмлэг маань зөвхөн соёлоор харилцах төдийгүй, найрамдлаар харилцах байгууллага болж өргөжсөн юм.

1970-аад оны дунд үеэс эхлэн МЭТНБХ, МЗНН нь ГОНСХЗНХ, ЗМНН-тэй хамтран ажиллах Протоколын үндсэн дээр хамтын үйл ажиллагаагаа явуулах болсон билээ.

1977 оноос МЗНН нь ЗСБНХУ-ын өдрүүдийг Зөвлөлтийн аль нэг бүгд найрамдах улсын жишээн дээр зохион явуулж эхэлсэн байна. Зөвлөлтийн холбооны болон автономит бүгд найрамдах улсын жишээн дээр ЗХУ-ын соёл, УААА-н тодорхой салбарыг сурталчлах ЗСБНХУ-ын өдрүүдийн арга хэмжээ нь Зөвлөлтийн ард түмний амьдрал, ололт амжилт, Зөвлөлт төрийн дотоод, гадаад бодлогыг Монголын ард түмэнд илүү ойр дөхөм танилцуулах өргөн боломжийг олгож байв.

МЗНН улс орны хооронд төдийгүй аймаг, хот, орон нутгийн түвшинд харилцаа тогтоох, хөгжүүлэхэд их хувь нэмэр оруулсан юм. Ийм ч учраас ЗХУ-ын холбооны болон автономит бүгд найрамдах улсууд, хязгаар, мужуудтай шууд харилцаа тогтоох, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх явдал МЗНН-ийн үйл ажиллагааны бас нэг чухал чиглэл байсан юм. Энэ чиглэлийн үйл ажиллагааны үр дүнд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт болон бүх аймгууд Зөвлөлтийн зохих субъектуудтай шууд харилцаа тогтоон ажиллаж байсан нь зохих үр шимээ өгч байсныг тэмдэглэн хэлэхийг хүсч байна.

Хөгжингүй орны тэргүүн туршлагыг аль нэг орон нэвтрүүлэх нь тухайн улс орны хөгжил, дэвшилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ утгаар МЗНН-ээс санаачлан явуулж байсан Зөвлөлтийн тэргүүн туршлагыг нэвтрүүлэх ажил нь манай орны бүхий л салбарын цаашдын өсөлт хөгжилд чухал ач холбогдолтой зүйл байсан гэж бид үздэг.

Манай хоёр орны олон нийтийн ажил хэрэгч хамтын ажиллагааг бэхжүүлэхэд 1958 онд байгуулагдсан Зөвлөлт-Монголын найрамдлын нийгэмлэг их үүрэг гүйцэтгэсэн юм. Тус нийгэмлэгийн анхны даргаар

иргэний дайны домогт жанжин, ЗХУ-ын 3 удаагийн баатар, ЗХУ-ын маршал С.М.Будённый ажиллаж байв. Энэ нийгэмлэгийн залгамж байгууллага болох Монголын анд нөхдийн Нийгэмлэг нь Монгол-Оросын найрамдлыг бэхжүүлэх ЗМНН-ийн сайхан уламжлалыг нэр төртэй үргэлжлүүлж байна. Монголын анд нөхдийн Нийгэмлэгийг 1974 оноос хойш тасралтгүй тэргүүлж, Орос-Монголын найрамдлыг бэхжүүлэх үйлсэд их хувь нэмэр оруулж байгаа В.В.Горбаткод Найрамдлын Нийгэмлэгүүдийн Монголын Эвлэл, “Монгол-Орос” найрамдлын Нийгэмлэгийн өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлье!

Монгол-Зөвлөлтийн найрамдлын Нийгэмлэг нь зөвхөн Гадаад орнуудтай найрамдал, соёлоор харилцах зөвлөлтийн нийгэмлэгүүдийн Холбоо, Зөвлөлт-Монголын найрамдлын Нийгэмлэг төдийгүй мөн тэдгээрийн бүс нутгийн салбар байгууллагуудтай хамтран ажилладаг уламжлалтай байв. Энэхүү сайхан уламжлал өнөө үед ОХУ-ын зарим бүс нутгуудад сэргэж байгааг бид сайшаан тэмдэглэхийг хүсч байна. 2000 оноос хойш ОХУ-ын Москва, Буриад, Халимаг, Усть-Ордын буриадын үндэсний тойрог, Новосибирск, Эрхүү мужуудад Монголын соёлын өдрүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран Найрамдлын байгууллагын шугамаар зохион явууллаа.

Гуравдугаар үе шат (1992 оноос өнөө үе)

Манай байгууллагын түүхэн хөгжлийн 3-р үе шат 1992 оноос өнөөдрийг хүртэлх үеийг хамарч байгаа бөгөөд Монгол-Оросын харилцааны шинэ үетэй давхцаж байгаа юм. Хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг чиг хандлага болох зах зээлийн харилцаанд шилжих шинэ цагийн дуудлагатай уялдуулан МЗНН-ийг 1992 онд “Найрамдлын Нийгэмлэгүүдийн Монголын Эвлэл” болон өөрчлөн зохион байгуулсан билээ. Энэ үеэс хуучнаар ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улс орнуудтай найрамдах нийгэмлэгүүд байгуулагдаж ННМЭ-ийн бүрэлдэхүүнд үйл ажиллагаа явуулж эхэлсэн түүхтэй юм.

Өнөөдөр ННМЭ-ийн бүрэлдэхүүнд 10 гаруй нийгэмлэг, холбоо нэгдэн ажиллаж байна. ННМЭ нь 15 жилийн хугацаанд шинэ цаг үед нийцсэн үйл ажиллагаа явуулж, өнөөгийн нөхцөлд амьдрах чадвартайгаа нотлон харуулж байна. ННМЭ, МОНН-ийн хамт МОКС-ын эхлүүлсэн ОХУ, ТУХН-ийн орнуудтай тогтоосон найрамдлыг шинэ цаг үед бэхжүүлэх үйл хэргийг нэр төртэй үргэлжлүүлж байгаа.

ННМЭ, МОНН Монгол-Оросын найрамдал, олон талт хамтын ажиллагааг хөгжүүлж бэхжүүлэх үйлсэд ОХУ-ын ГЯЯ-ны дэргэдэх Олон улсын шинжлэх ухаан, соёлын хамтын ажиллагааны Оросын Төв, Монголын анд нөхдийн Нийгэмлэг, манай оронд ажиллаж байгаа ОХУ-

ын ЭСЯ, Оросын шинжлэх ухаан, соёлын Төв, Москва хотын Засгийн газар, ОХУ-ын Эрхүү, Новосибирск муж, Буриад улс, Алтайн хязгаарын төлөөлөгчийн газрууд, ОХУ (ЗХУ)-д сургууль төгсөгчдийн олон улсын “ИНКОРВУЗ-XXI” холбоотой нягтаар хамтран ажиллаж шинэ Монгол, шинэ Орос орны хоорондын харилцаа, хамтын ажиллагааг цогцлон бүрдүүлж хөгжүүлэхэд төр засагтаа дэмжлэг үзүүлж, өөрийн зохих хувь нэмрийг оруулж байна.

ННМЭ-ийн өнөөгийн үйл ажиллагааны чухал зорилт бол:

- ОХУ, ТУХН-ийн орнуудын ард түмэнтэй тогтоосон найрамдлыг бэхжүүлэхийн тулд эдгээр орнуудын найрамдлын байгууллагууд, төв, хөдөлгөөнүүдтэй хамтын ажиллагаагаа цаашид хөгжүүлэх;

- Тусгаар тогтносон, ардчилсан эрх зүйт ОХУ, ТУХН-ийн орнуудын талаарх бүх талын, бодит ойлголт, төсөөллийг монголын олон нийтэд төлөвшүүлэхэд тус дөхөм үзүүлэх;

- Тусгаар тогтносон, ардчилсан эрх зүйт Монгол орны талаарх бүх талын, үнэн зөв, бодит ойлголтыг ОХУ, ТУХН-ийн орнуудын олон нийтэд төлөвшүүлэхэд тус дөхөм үзүүлэх;

- Нийгэм-эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан, оюуны болон хүмүүнлэгийн салбарт байнгын мэдээлэл солилцох талаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;

- ОХУ, ТУХН-ийн орнуудын болон олон улсын засгийн газрын бус байгууллагуудтай харилцах харилцааг бүх талаар хөгжүүлэх;

- Уран бүтээлч хамт олон, уран бүтээлчдийн тоглолт, телекино өдөр, уран сайхны болон ардын урлалын бүтээл, гэрэл зургийн үзэсгэлэн, найрамдлын өдөр, сарын ажлуудыг зохион явуулах;

- Орос хэлийг монголын олон нийтэд заан сургах, түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

- Ардын дипломатыг хөгжүүлэх, түүний бүхий л боломж, аргуудыг үр ашигтайгаар ашиглахад ажил хэрэгчээр оролцох;

- Монгол Улс, ОХУ болон ТУХН-ийн орнуудын байгууллага, хамт олон, субъектуудын түншлэлийн харилцааг хүмүүнлэгийн, шинжлэх ухаан-техникийн, соёл, боловсрол, мэргэжлийн салбарт цаашид хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг юм.

Олон ургалч үзэл, улс төрийн янз бүрийн үзэл, баримтлал чөлөөт оршин, нийгмийг ардчилах үйл явц гүнзгийрч байгаа өнөө үед найрамдлын байгууллагуудын үйл ажиллагаа уян хатан болж, хүндээ ойртон, агуулга нь эрс өөрчлөгдлөө. Монгол орны өмнө зогсож байгаа глобал асуудлуудыг шийдвэрлэхэд манай төр засаг, иргэний, ардчилсан, эрх зүйт нийгмийн чухал зэвсэг болсон төрийн бус

байгууллагуудын хүч, оролцоо, эрмэлзлийг ашиглан, хамтран ажиллах нь өнөө үед чухал байна.

Байгуулагдсан цагаасаа эхлэн ард түмэнтэйгээ хувь тавилангаа холбож, хөгжил дэвшлийнх нь зам өөд үргэлж цуг явж ирсэн найрамдлын ууган байгууллага маань цаашид ч гэсэн түүхэн уламжлалдаа үнэнч байж, шинэ шинэ агуулга хэлбэрээр баяжин хөгжиж байх учиртай бөгөөд, тэгж ч чадна гэдэгт бид бүхэн итгэлтэй байдаг юм.

ОХУ, Монгол орон бол мөнхийн хөршүүд. Бид газар нутаг, хувь тавилангаараа холбогдсон ард түмнүүд. Монголын ард түмэн үеийн үед итгэл, найдвар, гэгээлэг, чин үнэнч сайхан сэтгэлээр Оросын ард түмэнд хандаж, хүндэтгэж ирсэн юм. Манай ард түмний энэхүү сайхан сэтгэлийн мэдрэмж нь найрамдлын нийгэмлэгүүдийн амьдрах, үйл ажиллагааг нь тэтгэх амин сүнс, эх сурвалж нь болж байдаг. Монголын ард түмний энэхүү эерэг мэдрэмжийг цаашид бататган төлөвшүүлэхэд “Их өрийг” тэглэсэн асуудал түүхэн үүрэг гүйцэтгэсэн гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй юм.

Хүндэт зочид, төлөөлөгчид өө!

Нэгэн жаранг элээж, ард түмнийхээ нийтлэг эрх ашгийн төлөө төр, ард түмэнтэйгээ цуг явж ирсэн, гадаадтай соёлоор харилцах Монголын ууган нийгэмлэгийн түүхт ойг тохиолдуулан та бүхэнд чин сэтгэлийн баярын мэндчилгээг дэвшүүлж, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе! Олон улсын бага хурлын ажиллагаанд амжилт хүсье!